



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/214

Булган

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13, 16 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын хамтарсан 2019 оны А/41, А/51 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм, хийд болон хүүхэд асрах үйлчилгээг нэвтрүүлэн хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ эрхэлж буй асрамж, халамжийн төвийн стандартын хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Б.Одхүү - Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд: Д.Алтаншагай - Аймгийн Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга
Н.Одонхүү - Аймгийн тагнуулын хэлтсийн ажилтан
Т.Наранцэцэг - Татварын хэлтсийн байцаагч
Л.Байгалмаа - Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч
Н.Хишигдорж - Онцгой байдлын газрын
Б.Батчулуун - Цагдаагийн газрын цагдаагийн ахмад
Б.Отгонжаргал - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Дэлгэрмөрөн - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, хүүхдийн эрхийн байцаагч

2. Хяналт, шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар ханган, шалгалтын дүн мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б.Одхүү/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ц.БАТ-ӨЛЗИЙ

20190222